



2025 оны 12 сар

НИЙСЛЭЛИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТӨД ХИЙСЭН ТОЙМ ДҮГНЭЛТ

Д.Баярмаа


Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт нь хотын дэд бүтцийг хөгжүүлэх, нийтийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн амьдрах орчныг сайжруулах, нийслэлийн тогтвортой хөгжлийг дэмжих үндсэн хэрэгсэл юм. Энэхүү судалгааны зорилго нь нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний ерөнхий төлөвлөлтөд тойм дүгнэлт хийж, асуудал дэвшүүлэхэд чиглэж байна.

Нийслэлийн 2026 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг нийт 4.1 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Нийслэлийн 2026 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг нийт 4.1 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 12.3 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 98 төсөл, арга хэмжээг 1.67 их наяд төгрөгөөр, Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 2.8 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 56 төсөл, арга хэмжээг 227.9 тэрбум төгрөгөөр, Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр хэрэгжүүлэх 2 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээг 1.3 их наяд төгрөгөөр, Нийслэлийн орон нутгийн

хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 17 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 70 төсөл, арга хэмжээг 17 тэрбум төгрөгөөр, Нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийг 34 тэрбум төгрөгөөр, Газрыг дахин төлөвлөх гэр хорооллын хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийг 80 тэрбум төгрөгөөр тус тус санхүүжүүлнэ гэж тусгажээ. Мөн 2025-2026 он дамжин санхүүжих 321 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг 761.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлнэ гэж төлөвлөсөн.

Зураг 1. Нийслэлийн 2026 оны хөрөнгө оруулалтын зардал (эх үүсвэрээр)



2026 ОНД НИЙТ САНХҮҮЖИХ ДҮН: 4.1 ИХ НАЯД ₮

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖИХ ТӨСЛҮҮД

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийн 5.5 хувь, тухайн онд санхүүжих дүнгийн 31.2 хувь шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээнд ногдож байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд нийт 12.3 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 1.67 их наяд төгрөгийн санхүүжих дүнтэй 98 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төсвийн төсөлд тусгажээ. Үүнээс 679.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй шинээр хэрэгжих 50 төсөл, арга хэмжээг 519.9 тэрбум төгрөгөөр, 11.6 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 48 шилжих төсөл, арга хэмжээг 1.4 их наяд төгрөгөөр

тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн. 2026 онд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын нийт төсөвт өртгийн 5.5 хувь, тухайн онд санхүүжих дүнгийн 31.2 хувь шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээнд хуваарилагдсан нь нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт өмнөх жилээс шилжиж ирсэн төслүүдэд төвлөрч байгааг харуулж байна.

Хүснэгт 1. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих төсөл, арга хэмжээ, шинээр хэрэгжих ба шилжих (тэрбум төгрөг)

Ангилал	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг		2026 онд санхүүжих дүн	
		Тэрбум төгрөг	Хувийн жин	Тэрбум төгрөг	Хувийн жин
Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ	50	679.4	5.5%	519.9	31.2%
Шилжих төсөл, арга хэмжээ	48	11,642.5	94.5%	1,148.8	68.8%
Нийт	98	12,321.9	100%	1,668.7	100%

Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих төсөл арга хэмжээний тоо өмнөх оноос буурсан ч нийт төсөвт өртөг ба санхүүжих дүн өссөн байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо өмнөх 2025 онтой харьцуулахад 44-өөр буурсан боловч нийт

төсөвт өртөг 9.5 их наяд төгрөгөөр, тухайн онд санхүүжих дүн 101.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 2. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025, 2026 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртөг, санхүүжих дүн (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Нийслэлийн 2025 оны төсөв, Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл

ШИНЭЭР ХЭРЭГЖИХ ТӨСЛҮҮДИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдийн нийт төсөвт өртгийн 78 хувь, нийт санхүүжих дүнгийн 76 хувь барилга байгууламжийн төслүүдэд ногдож байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээг эдийн засгийн ангиллаар авч үзвэл 529.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 395.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 27 барилга байгууламж, 83.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 78.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 10 их засвар, 32.8 тэрбум

төгрөгийн төсөвт өртөгтэй, 31.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 10 тоног төхөөрөмж, 33.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 15.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 3 зураг төсөв төлөвлөжээ. Барилга байгууламж нийт төсөвт өртгийн 78 хувь, санхүүжилтийн 76 хувийг, их засвар нийт төсөвт өртгийн 12.3 хувь, санхүүжилтийн 15.1 хувь, тоног

төхөөрөмж нийт төсөвт өртгийн 4.9 хувь, санхүүжилтийн 2.9 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 2. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ, эдийн засгийн ангиллаар (тэрбум төгрөг)

Ангилал	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг		2026 онд санхүүжих дүн	
		Тэрбум төгрөг	Хувийн жин	Тэрбум төгрөг	Хувийн жин
Барилга байгууламж	27	529.6	78.0%	395.2	76.0%
Их засвар	10	83.6	12.3%	78.3	15.1%
Тоног төхөөрөмж	10	32.8	4.8%	31.1	6.0%
Зураг төсөв	3	33.3	4.9%	15.3	2.9%

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл

Хамгийн өндөр төсөвт өртөгтэй шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдэд 240 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл арга, хэмжээний газар чөлөөлөлт, нөхөн олговор, 59.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Гадаадын зээл тусламжаар хэрэгжих төслүүдийн нийслэлийн

хариуцах хөрөнгө, 40 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасад, засварын ажил, 25.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, дагуул хотыг хөгжүүлэх, ХЕТ боловсруулах төсөл багтаж байна (Хавсралт 1).

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдийн нийт төсөвт өртгийн 54.8 хувь, нийт санхүүжих дүнгийн 65.9 хувь нь хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалтын төслүүдэд ногдож байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдийг зориулалтаар нь авч үзвэл 372.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 342.7 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 14 төсөл, арга хэмжээ хот байгуулалт, барилга стандарт, хяналт, зохицуулалтад, 188.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 75.4 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 23 төсөл, арга хэмжээ нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалтад, 59.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг ба санхүүжих дүнтэй 3 төсөл, арга хэмжээ орон сууц, нийтийн аж ахуйн удирдлага, үйлчилгээнд, 31.3 тэрбум төгрөгийн

төсөвт өртөгтэй, 20.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 3 төсөл, арга хэмжээ нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламжид, 7.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 3.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 1 төсөл, арга хэмжээ цэвэрлэх байгууламж, үерийн далан, суваг шуудууд, 5.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг ба санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээ цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, сувгийн барилга байгууламжид ангилагдаж байна.

Хүснэгт 3. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ, зориулалтаар (тэрбум төгрөг)

Ангилал	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг		2026 онд санхүүжих дүн	
		Тэрбум төгрөг	Хувийн жин	Тэрбум төгрөг	Хувийн жин
Хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалт	14	372.1	54.8%	342.7	65.9%
Нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт	23	188.9	27.8%	75.4	14.5%
Орон сууц, нийтийн аж ахуйн удирдлага, үйлчилгээ	3	59.8	8.8%	59.8	11.5%
Нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж	3	31.3	4.6%	20.3	3.9%
Цэвэрлэх байгууламж, үерийн далан, суваг шуудуу	1	7.8	1.2%	3.9	0.8%

Цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, сувгийн барилга байгууламж	2	5.2	0.8%	5.2	1.0%
Бусад	4	14.2	2.1%	12.5	2.4%

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдийн нийт төсөвт өртгийн 63.7 хувь, нийт санхүүжих дүнгийн 82.6 хувь Улаанбаатар хотын хэмжээнд хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдэд ногдоно.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдийг байршлаар нь авч үзвэл 433.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 429.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 24 төсөл, арга хэмжээ Улаанбаатар хотын хэмжээнд, 67.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 27.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 9 төсөл, арга хэмжээ Баянзүрх дүүрэгт, 60.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 14.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 4 төсөл, арга хэмжээ Сонгинохайрхан дүүрэгт, 56.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 17.4 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 6 төсөл, арга хэмжээ

Сүхбаатар дүүрэгт, 25.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 7.7 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 1 төсөл, арга хэмжээ Сонгинохайрхан дүүрэг, Яармаг, Амгалан, Баянхошуу, Чингэлтэй хотод, 22.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 12.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 3 төсөл, арга хэмжээ Хан-Уул дүүрэгт, 10 тэрбум төгрөгийн төсөвт өртөг ба санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээ Баянгол дүүрэгт, 2.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 1 төсөл, арга хэмжээ Багануур дүүрэгт тус тус хэрэгжинэ.

Хүснэгт 4. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ, байршлаар (тэрбум төгрөг)

Байршил	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг		2026 онд санхүүжих дүн	
		Тэрбум төгрөг	Хувийн жин	Тэрбум төгрөг	Хувийн жин
Улаанбаатар*	24	433.1	63.7%	429.5	82.6%
Баянзүрх дүүрэг	9	67.7	10.0%	27.9	5.4%
Сонгинохайрхан дүүрэг	4	60.8	8.9%	14.1	2.7%
Сүхбаатар дүүрэг	6	56.4	8.3%	17.4	3.4%
Сонгинохайрхан дүүрэг, Яармаг, Амгалан, Баянхошуу, Чингэлтэй хот	1	25.8	3.8%	7.7	1.5%
Хан-Уул дүүрэг	3	22.8	3.3%	12.2	2.3%
Баянгол дүүрэг	2	10.0	1.5%	10.0	1.9%
Багануур дүүрэг	1	2.9	0.4%	1.0	0.2%

**Тодорхой байршил заагаагүй эсвэл Улаанбаатар хотын хэмжээнд хэрэгжих төсөл, арга хэмжээнүүд*
Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих 10 төсөл, арга хэмжээний эхний санхүүжилтийг хуулийн дагуу төлөвлөөгүй байна.

Төсвийн тухай хуулийн “29.3.5 Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах” гэсэн заалтын дагуу эхний санхүүжилт буюу 2026 онд санхүүжих дүнг хуулийн дагуу төлөвлөөгүй нийт 10 төсөл, арга хэмжээ байна (Хавсралт 2). Үүнд: 2 жилийн хугацаанд хэрэгжих, эхний санхүүжилт нь төсөвт өртгийн 50 хувиас бага 3 төсөл, арга хэмжээ, 3 жилийн хугацаанд хэрэгжих, эхний санхүүжилт нь төсөвт өртгийн 33.3 хувиас бага 7 төсөл, арга хэмжээ байна. Эдгээр 10 төсөл, арга хэмжээний 2026 онд санхүүжвэл зохих 51 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 17.5 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн буюу 33.5 тэрбум төгрөгөөр дутуу төлөвлөжээ.

Санхүүжилтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнд Баянзүрх дүүргийн 26-р хороо ба Сонгинохайрхан дүүргийн 23-р хороонд хэрэгжих 640 суудалтай сургуулийн барилга, Сэлбэ дэд төв, Баянголын аманд хэрэгжих 960 суудалтай сургуулийн барилга, Хан-Уул дүүргийн 23-р хороонд хэрэгжих 240 ортой цэцэрлэгийн барилга, Баянзүрх дүүргийн 14-р хороонд хэрэгжих цэцэрлэгийн барилга, Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, дагуул хотыг хөгжүүлэх, ХЕТ боловсруулах ажил, Багануур дүүргийн 1-р хорооны эрүүл мэндийн төвийн барилгын дотор засварын ажил, Монголын хүүхдийн урлан бүтээх төвийн барилгын хүчитгэлийн ажил, Байгаль орчны хяналтын нэгдсэн систем хангамжийн ажил багтаж

ӨМНӨХ ОНООС ШИЛЖИХ ТӨСЛҮҮДИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих шилжих төсөл, арга хэмжээнүүдийн нийт санхүүжих дүнгийн 97.2 хувь барилга байгууламжийн төслүүдэд ногдож байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих шилжих төсөл, арга хэмжээг эдийн засгийн ангиллаар авч үзвэл 11.6 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 1.1 их наяд төгрөгийн санхүүжих дүнтэй 42 барилга байгууламж, 17.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 7.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 4 их засвар, 33.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 24.2 тэрбум төгрөгийн санхүүжих

дүнтэй 2 тоног төхөөрөмж төлөвлөжээ. Барилга байгууламж шилжих төсөл, арга хэмжээнүүдийн нийт төсөвт өртгийн 99.6 хувь, нийт санхүүжих дүнгийн 97.2 хувийг, их засвар нийт төсөвт өртгийн 0.2 хувь, нийт санхүүжих дүнгийн 0.7 хувь, тоног төхөөрөмж нийт төсөвт өртгийн 0.3 хувь, нийт санхүүжих дүнгийн 2.1 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 5. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих шилжих төсөл, арга хэмжээ, эдийн засгийн ангиллаар (тэрбум төгрөг)

Ангилал	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг		2026 онд санхүүжих дүн	
		Тэрбум төгрөг	Хувийн жин	Тэрбум төгрөг	Хувийн жин
Барилга байгууламж	42	11,591.3	99.6%	1,116.8	97.2%
Их засвар	4	17.9	0.2%	7.9	0.7%
Тоног төхөөрөмж	2	33.3	0.3%	24.2	2.1%

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих шилжих төсөл, арга хэмжээнүүдийн нийт санхүүжих дүнгийн 68 хувь нь авто замын түгжрэлийг бууруулахад зориулагдана.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих шилжих төсөл, арга хэмжээнүүдийг зориулалтаар нь авч үзвэл 2.4 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 780.7 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 1 төсөл, арга хэмжээ авто замын түгжрэлийг бууруулахад, 8.5 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 127.6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээ нийслэлийн нийтийн тээвэр, такси үйлчилгээний зохицуулалтад, 286.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 101.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 22 төсөл, арга хэмжээ нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалтад, 285.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 66.6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 5 төсөл, арга хэмжээ цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, сувгийн барилга байгууламжид, 102.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 54.1 тэрбум

төгрөгийн санхүүжих дүнтэй 10 төсөл, арга хэмжээ хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалтад, 25.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 7.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээ нийслэлийн хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлтөд, 6.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 3.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээ нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламжид, 1.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 0.4 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 1 төсөл, арга хэмжээ орон сууц, нийтийн аж ахуйн удирдлага, үйлчилгээнд ангилагдаж байна. Авто замын түгжрэлийг бууруулах төсөл, арга хэмжээнд шилжих төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийн 20.5 хувь, нийт санхүүжих дүнгийн 68 хувь ногдож байна.

Хүснэгт 6. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих шилжих төсөл, арга хэмжээ, зориулалтаар (тэрбум төгрөг)

Ангилал	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг		2026 онд санхүүжих дүн	
		Тэрбум төгрөг	Хувийн жин	Тэрбум төгрөг	Хувийн жин
Авто замын түгжрэлийг бууруулах төсөл, арга хэмжээний жагсаалт	1	2,384.0	20.5%	780.7	68.0%

Нийслэлийн нийтийн тээвэр, такси үйлчилгээний зохицуулалт	2	8,533.7	73.3%	127.6	11.1%
Нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт	22	286.7	2.5%	101.2	8.8%
Цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, сувгийн барилга байгууламж	5	285.5	2.5%	66.6	5.8%
Хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалт	10	102.2	0.9%	54.1	4.7%
Нийслэлийн хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт	2	25.6	0.2%	7.5	0.7%
Нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж	2	6.9	0.1%	3.3	0.3%
Орон сууц, нийтийн аж ахуйн удирдлага, үйлчилгээ	1	1.8	0.02%	0.4	0.03%
Бусад	3	16.1	0.1%	7.5	0.7%

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих шилжих төсөл, арга хэмжээнүүдийн нийт санхүүжих дүнгийн 90 хувь Улаанбаатар хотын хэмжээнд хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдэд ногдоно.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих шилжих төсөл, арга хэмжээнүүдийг байршлаар нь авч үзвэл 11.3 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 1 их наяд төгрөгийн санхүүжих дүнтэй 13 төсөл, арга хэмжээ Улаанбаатар хотын хэмжээнд, 79 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 28 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 6 төсөл, арга хэмжээ Хан-Уул дүүрэгт, 59.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 19.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 7 төсөл, арга хэмжээ Баянзүрх дүүрэгт, 55.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 22 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 4 төсөл, арга хэмжээ Баянгол

дүүрэгт, 47.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 23.6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 10 төсөл, арга хэмжээ Сонгинохайрхан дүүрэгт, 33.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 10.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 3 төсөл, арга хэмжээ Сүхбаатар дүүрэгт, 21.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 8.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээ Чингэлтэй дүүрэгт, 11.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 3.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээ Багануур дүүрэгт хэрэгжинэ.

Хүснэгт 7. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих шилжих төсөл, арга хэмжээ,, байршлаар (тэрбум төгрөг)

Байршил	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг		2026 онд санхүүжих дүн	
		Тэрбум төгрөг	Хувийн жин	Тэрбум төгрөг	Хувийн жин
Улаанбаатар*	13	11,334.5	97.4%	1,033.6	90.0%
Хан-Уул дүүрэг	6	79.0	0.7%	28.0	2.4%
Баянзүрх дүүрэг	7	59.3	0.5%	19.1	1.7%
Баянгол дүүрэг	4	55.7	0.5%	22.0	1.9%
Сонгинохайрхан дүүрэг	10	47.5	0.4%	23.6	2.1%
Сүхбаатар дүүрэг	3	33.1	0.3%	10.1	0.9%
Чингэлтэй дүүрэг	2	21.6	0.2%	8.9	0.8%
Багануур дүүрэг	2	11.7	0.1%	3.5	0.3%

*Тодорхой байршил заагаагүй эсвэл Улаанбаатар хотын хэмжээнд хэрэгжих төсөл, арга хэмжээнүүд

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих шилжих төсөл, арга хэмжээнүүдэд 4-өөс дээш жил хэрэгжих 16 төсөл, арга хэмжээ багтаж байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих шилжих, төсөл арга хэмжээнүүдэд 8 жилийн хугацаанд хэрэгжих 1 төсөл, арга хэмжээ, 7 жилийн хугацаанд хэрэгжих 3 төсөл, арга хэмжээ, 6

жилийн хугацаанд хэрэгжих 2 төсөл, арга хэмжээ, 5 жилийн хугацаанд хэрэгжих 5 төсөл, арга хэмжээ, 4 жилийн хугацаанд хэрэгжих 5 төсөл, арга хэмжээ багтаж байна (Хавсралт 3).

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖИХ ТӨСЛҮҮД

Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2026 онд 239.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 164.8 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 48 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлнэ.

Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2026 онд нийт 2.8 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 227.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 56 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Нийт 239.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 164.8 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй шинээр хэрэгжих 48 төсөл, арга хэмжээ төлөвлөгдсөн. Үүнээс 163 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 101.8 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй, 19 төсөл арга хэмжээ нь авто зам, замын байгууламж шинээр барих болон шинэчлэлтэд,

46.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг ба санхүүжих дүнтэй 15 төсөл, арга хэмжээ нь авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтад, 26.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 126. тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй, 12 төсөл, арга хэмжээ нь борооны ус зайлуулах шугамд зориулагдана. Мөн 2.5 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 63 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй, 8 шилжих төсөл, арга хэмжээ Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжнэ.

Хүснэгт 8. Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих төсөл, арга хэмжээ (тэрбум төгрөг)

Ангилал	Шинээр хэрэгжих			Шилжих		
	Төсөл, арга хэмжээний тоо	Нийт төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн	Төсөл, арга хэмжээний тоо	Нийт төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
Авто зам, замын байгууламж шинээр барих болон шинэчлэлт	19	163.0	101.8	8	2,543.8	63.0
Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт	15	46.6	46.6	-	-	-
Борооны ус зайлуулах шугам	12	26.5	12.6	-	-	-
Бусад	2	3,780.0	3,780.0	-	-	-
Нийт	48	239.9	164.8	8	2,543.8	63.0

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл

Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2026 онд 2 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 1.3 их наяд төгрөгийн санхүүжих дүнтэй 3 шилжих төсөл, арга хэмжээ хэрэгжинэ.

Нийслэлийн үнэт цаасны хөрөнгө оруулалтаар 2026 онд нийт 2 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 1.3 их наяд төгрөгийн санхүүжих дүн 3 шилжих төсөл, арга хэмжээ хэрэгжинэ. Эдгээрт 59.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 28 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Ариутгах Бохир усны Туул-1 коллекторын байгууламжийн ажил, 293.6 тэрбум

төгрөгийн төсөвт өртөгтэй, 5.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Эрчим хүч хуримтлуурын станцын ажил, 1.6 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 1.3 их наяд төгрөгийн санхүүжих дүнтэй Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын төслүүд багтаж байна.

Хүснэгт 9. Нийслэлийн үнэт цаасны хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих төсөл, арга хэмжээ (тэрбум төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх он	Дуусах он	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
1	Ариутгах Бохир усны Туул-1 коллекторын байгууламжийн ажил (Улаанбаатар хот)	2024	2026	59.1	28.0
2	Эрчим хүч хуримтлуурын станцын ажил	2024	2026	293.6	5.1
3	Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хороолол	2024	2026	1,646.2	1,267.9
	Нийт			1,998.8	1,301.0

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл

НИЙСЛЭЛИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ ТӨСЛҮҮД

Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2026 онд 17 тэрбум төгрөгийн төсөвт өртөг ба санхүүжих дүнтэй 70 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлнэ.

Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2026 онд нийт 17 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 70 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэх төлөвлөсөн. Эдгээр төсөл, арга хэмжээнүүд нь бүгд 2026 ондоо багтаж дуусах ба бүрэн санхүүжигдэнэ. Үүнд, 3.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээ Баянзүрх дүүрэгт, 3.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээ Сонгинохайрхан дүүрэгт, 2.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл, арга

хэмжээ Хан-Уул дүүрэгт, 2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээ Баянгол дүүрэгт, 1.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээ Чингэлтэй дүүрэгт, 0.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээ Налайх дүүрэгт, 0.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээ Багануур дүүрэгт, 0.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээ Багахангай дүүрэгт тус тус хэрэгжинэ.

Хүснэгт 10. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ (тэрбум төгрөг)

№	Байршил	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
1	Баянзүрх дүүрэг	11	3.9	3.9
2	Сонгинохайрхан дүүрэг	12	3.6	3.6
3	Хан-Уул дүүрэг	10	2.3	2.3
4	Баянгол дүүрэг	11	2.0	2.0
5	Сүхбаатар дүүрэг	9	1.6	1.6
6	Чингэлтэй дүүрэг	4	1.6	1.6
7	Налайх дүүрэг	9	0.8	0.8
8	Багануур дүүрэг	3	0.8	0.8
9	Багахангай дүүрэг	1	0.4	0.4
Нийт			17.0	17.0

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл

ОН ДАМЖИН САНХҮҮЖИХ ТӨСЛҮҮДИЙН ТӨЛӨВЛӨЛТ

2025-2026 он дамжин санхүүжих 321 төсөл, арга хэмжээг 761.3 тэрбум төгрөгөөр 2026 онд санхүүжүүлнэ.

2025-2026 он дамжин санхүүжих нийт 10.72 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 321 төсөл, арга хэмжээг 2026 онд 761.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлнэ. Үүнээс 10.7 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 749.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 291 төсөл, арга хэмжээг Нийслэлийн төсвийн хөрөнгө

оруулалтаар, 18.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 12.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 30 төсөл, арга хэмжээг Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2026 онд санхүүжүүлнэ.

Хүснэгт 11. 2025-2026 он дамжин санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ (тэрбум төгрөг)

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	2026 онд дамжуулах дүн
1	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	291	10,704.1	749.1
2	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт	30	18.4	12.2
Он дамжих нийт дүн		321	10,722.5	761.3

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл

2026 онд дамжуулах дүн нь 10 тэрбум төгрөгөөс дээш дүнтэй Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар дамжин санхүүжих төсөл, арга хэмжээнүүдэд 75.8 тэрбум төгрөгийн дамжуулах дүнтэй Улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл тусламжаар

хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний газар чөлөөлөлт, нөхөн олговор, 40.5 тэрбум төгрөгийн дамжуулах дүнтэй дүнтэй Нийтийн эзэмшлийн явган хүний замыг шинээр болон шинэчлэн засварлах ажил, 30 тэрбум төгрөгийн дамжуулах дүнтэй Эмээлт аж

үйлдвэрийн паркийн дулааны цахилгаан станц, бохир ус цэвэрлэх байгууламжийн ажил, 26.3 тэрбум төгрөгийн дамжуулах дүнтэй Туулын авто замыг Нисэхийн хурдны авто замтай холбож, Наадамчдын авто зам дээгүүр гүүрэн байгууламжийн барилга угсралтын ажил, 26.3 тэрбум төгрөгийн дамжуулах дүнтэй Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадын зураг төсөв, засварын ажил, 26.3 тэрбум төгрөгийн дамжуулах дүнтэй Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро”-г барих төслийн бүтээн байгуулалтын ажил, 17.2 тэрбум төгрөгийн дамжуулах дүнтэй Тоньюкукийн замаас Плейтайм

аялал жуулчлалын цогцолбор газар хүртэлх авто зам, замын байгууламж, 20 тэрбум төгрөгийн дамжуулах дүнтэй Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжих төслүүдийн нийслэлийн хариуцах хөрөнгө, 15.2 тэрбум төгрөгийн дамжуулах дүнтэй Хотын аж ахуйн ажил үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, 10 тэрбум төгрөгийн дамжуулах дүнтэй Хүннү хотын эхний ээлжийн цэвэрлэх байгууламжийн ажил, 10 тэрбум төгрөгийн дамжуулах дүнтэй Эрүүл мэндийн байгууллагын агаар сэлгэлтийн системийг сайжруулах ажил төслүүд багтаж байна (Хавсралт 4).

ТОЙМ ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Дүгнэлт

Дүн шинжилгээний хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна:

- Нийслэлийн 2026 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг нийт 4.1 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд, 1.67 их наяд төгрөгийг Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар, 1.3 их наяд төгрөгийг Нийслэлийн үнэт цаасны хөрөнгө оруулалтаар, 227.9 тэрбум төгрөгийг Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар, 17 тэрбум төгрөгийг Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар, 34 тэрбум төгрөгийг Нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар, 80 тэрбум төгрөгийг Газрыг дахин төлөвлөх гэр хорооллын хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд нийт 12.3 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 1.67 их наяд төгрөгийн санхүүжих дүнтэй 98 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төсвийн төсөлд тусгажээ.
- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих төсөл арга хэмжээний тоо өмнөх оноос буурсан ч нийт төсөвт өртөг ба санхүүжих дүн өссөн байна.
- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдийн нийт төсөвт өртгийн 54.8 хувь, нийт санхүүжих дүнгийн 65.9 хувь нь хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалтын төслүүдэд ногдож байна.
- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдийн нийт төсөвт өртгийн 63.7 хувь, нийт санхүүжих дүнгийн 82.6 хувь Улаанбаатар хотын хэмжээнд хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдэд ногдоно.
- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих 10 төсөл, арга хэмжээний эхний санхүүжилтийг хуулийн дагуу төлөвлөөгүй байна. Эдгээр 10 төсөл,

арга хэмжээний 2026 онд санхүүжвэл зохих санхүүжилтийг 33.5 тэрбум төгрөгөөр дутуу төлөвлөжээ.

- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих шилжих төсөл, арга хэмжээнүүдийн нийт санхүүжих дүнгийн 68 хувь нь авто замын түгжрэлийг бууруулахад зориулагдана.
- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих шилжих төсөл, арга хэмжээнүүдийн нийт санхүүжих дүнгийн 90 хувь Улаанбаатар хотын хэмжээнд хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдэд ногдоно.
- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих шилжих төсөл, арга хэмжээнүүдэд 4-өөс дээш жил хэрэгжих 16 төсөл, арга хэмжээ багтаж байна.
- 2025-2026 он дамжин санхүүжих нийт 10.7 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 749.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 291 төсөл, арга хэмжээг Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлнэ.
- Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2026 онд 239.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 164.8 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 48 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлнэ.
- Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2026 онд 2 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 1.3 их наяд төгрөгийн санхүүжих дүнтэй 3 шилжих төсөл, арга хэмжээ хэрэгжинэ.
- Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2026 онд 17 тэрбум төгрөгийн төсөвт өртөг ба санхүүжих дүнтэй 70 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлнэ.

Санал, зөвлөмж

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр дараах санал, зөвлөмжийг гаргаж байна:

- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын дийлэнх хувь Улаанбаатар хотын хэмжээнд хэрэгжих төвлөрсөн төслүүдэд ногдож байгаа

тул цаашид дүүргүүдийн хөгжлийн бодлого, бодит хэрэгцээ, хүн амын нягтаршил, үйлчилгээний хүртээмжийн зөрүү зэрэгт тулгуурлан төслийн эрэмбэлэлт, хуваарилалт хийх;

- Шинээр хэрэгжих төслүүдийг Төсвийн тухай хуулийн шаардлагад нийцүүлж, эхний жилийн санхүүжилтийг бүрэн төлөвлөх;

- Шинээр хэрэгжих төслүүдийн бодит хэрэгцээ, үр ашгийг нарийвчлан үнэлэх;
- Шилжих төслүүдийн санхүүжилтийн график, гүйцэтгэлийн төлөвлөгөөг ил тод болгох;
- Сангуудын хоорондын уялдааг сайжруулах;
- Дамжин санхүүжиж буй төслүүдийн гүйцэтгэлд хяналт тавих тус тус болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- ❖ Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл (2025 оны 11-р сар, <https://khural.ulaanbaatar.mn/files/pdf2/cvf0oc7e0jb/69251a18f9b047338a080ea9.pdf>)
- ❖ Төсвийн тухай хууль

Хавсралт 1. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих 10 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний жагсаалт (сая төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн	Эдийн засгийн ангилал	Зориулалт
1	Улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл арга, хэмжээний газар чөлөөлөлт, нөхөн олговор (Улаанбаатар хот)	2026	240,000.0	240,000.0	Барилга байгууламж	Хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалт
2	Гадаадын зээл тусламжаар хэрэгжих төслүүдийн нийслэлийн хариуцах хөрөнгө (Улаанбаатар хот)	2026	59,440.1	59,440.1	Барилга байгууламж	Хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалт
3	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасад, засварын ажил (Улаанбаатар хот)	2026	40,000.0	40,000.0	Их засвар	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдлага, үйлчилгээ
4	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, дагуул хотыг хөгжүүлэх, ХЕТ боловсруулах (Сонгинохайрхан, Яармаг, Амгалан, Баянхошуу, Чингэлтэй хот)	2028	25,760.7	7,728.2	Зураг төсөв	Хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалт
5	Сургуулийн барилга, 640 суудал (Баянзүрх дүүрэг, 26-р хороо)	2028	25,200.0	5,000.0	Барилга байгууламж	Нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт
6	Сургуулийн барилга, 960 суудал (Сэлбэ дэд төв)	2028	25,200.0	5,000.0	Барилга байгууламж	Нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт
7	Сургуулийн барилга, 960 суудал (Баянголын ам)	2028	25,200.0	5,000.0	Барилга байгууламж	Нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт
8	Сургуулийн барилга, 640 суудал (Сонгинохайрхан дүүрэг, 23-р хороо)	2028	25,000.0	5,000.0	Барилга байгууламж	Нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт
9	Түймэрт өртсөн 207 дугаар байрыг шинээр барилгажуулах ажил (Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо)	2027	17,340.0	8,670.0	Барилга байгууламж	Хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалт
10	Ногоон нуур орчмын тохижилт ногоон байгууламж (Сүхбаатар дүүрэг, 9 дүгээр хороо)	2028	16,505.0	5,502.0	Барилга байгууламж	Нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж
11	Спорт цогцолборын спортын барилгын нэмэлт ажил (Хан-уул дүүрэг, 8-р хороо)	2027	15,000.0	10,000.0	Барилга байгууламж	Нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт
12	"Хүннү хот"-ын дэд бүтцийн ажил (Улаанбаатар хот)	2026	10,820.0	10,820.0	Барилга байгууламж	Хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалт
13	Гэр хорооллын гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах ажил (Улаанбаатар хот)	2026	10,000.0	10,000.0	Их засвар	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдлага, үйлчилгээ
14	Нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбайн тохижилтын нэмэлт ажил (Улаанбаатар хот)	2026	10,000.0	10,000.0	Барилга байгууламж	Нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл

Хавсралт 2. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжих төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт (сая төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн	2026 онд санхүүжвэл зохих дүн	2026 онд дутуу төлөвлөсөн санхүүжилт
1	Сургуулийн барилга, 640 суудал (Баянзүрх дүүрэг, 26-р хороо)	2028	25,200.0	5,000.0	8,400.0	3,400.0
2	Сургуулийн барилга, 960 суудал (Сэлбэ дэд төв)	2028	25,200.0	5,000.0	8,400.0	3,400.0
3	Сургуулийн барилга, 960 суудал (Баянголын ам)	2028	25,200.0	5,000.0	8,400.0	3,400.0
4	Сургуулийн барилга, 640 суудал (Сонгинохайрхан дүүрэг, 23-р хороо)	2028	25,000.0	5,000.0	8,333.3	3,333.3
5	Цэцэрлэгийн барилга, 240 ор (Хан-Уул дүүрэг, 23-р хороо)	2028	6,900.0	1,300.0	2,300.0	1,000.0
6	Цэцэрлэгийн барилга (Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Консулын 6-9 дүгээр гудамж)	2028	7,808.8	1,656.4	2,602.9	946.5
7	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, дагуул хотыг хөгжүүлэх, ХЕТ боловсруулах	2028	25,760.7	7,728.2	8,586.9	858.7
8	Эрүүл мэндийн төвийн барилгын дотор засварын ажил (Багануур дүүрэг, 1 дүгээр хороо)	2027	2,860.4	1,000.0	1,430.2	430.2
9	Монголын хүүхдийн урлан бүтээх төвийн барилгын хүчитгэлийн ажил	2027	2,452.0	830.1	1,226.0	395.9
10	Байгаль орчны хяналтын нэгдсэн систем хангамжийн ажил	2027	2,700.0	1,000.0	1,350.0	350.0
	Нийт		149,081.9	33,514.7	51,029.3	17,514.6

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл

Хавсралт 3. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих шилжих төсөл, арга хэмжээний жагсаалт, 4 жилээс дээш хугацаанд хэрэгжих (сая төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх он	Дуусах он	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
1	Баянгол дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэр "А" хэсэгчилсэн талбайн эхний ээлжийн инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил	2019	2026	4,139.2	1,668.7
2	Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро"-г барих төслийн бүтээн байгуулалтын ажил (Улаанбаатар хот)	2024	2030	8,387,792.7	110,000.0
3	Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро"-г барих төслийн зөвлөх үйлчилгээ	2024	2030	145,911.0	17,600.0
4	Сургуулийн барилга, 640 суудал (Чингэлтэй дүүрэг, 8-р хороо)	2020	2026	13,258.6	5,320.8
5	Аддиктологийн төвийн барилга (Баянгол дүүрэг, 20-р хороо)	2022	2027	32,709.3	7,449.1
6	Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээний зураг, төсөл, барилга угсралтын ажил (Хан-Уул дүүрэг)	2022	2027	9,950.0	2,000.0
7	Эрүүл мэндийн төвийн цогцолбор (Баянзүрх дүүрэг, 24-р хороо)	2022	2026	13,063.0	4,963.0
8	Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэр орчмын "В" хэсэгчилсэн талбайн гадна инженерийн шугам сүлжээний ажил	2022	2026	6,370.0	1,586.4
9	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор (Сонгинохайрхан дүүрэг, 26-р хороо)	2022	2026	5,959.6	2,460.9
10	Инженерийн шугам сүлжээ (Сонгинохайрхан дүүрэг, 24 дүгээр хороо)	2022	2026	2,974.7	1,974.7
11	Сургуулийн барилга, 640 суудал (Хан-Уул дүүрэг, 18-р хороо)	2024	2028	9,400.0	2,500.0
12	Сургуулийн барилга буулгаж шинээр барих 960 суудал (Баянзүрх дүүрэг, 30-р сургууль)	2024	2027	26,277.6	10,000.0
13	Сэлбэ голын явган хүний гүүр, тохижилтын ажил (Баянзүрх дүүрэг, 43-р хороо)	2023	2026	684.7	220.3
14	"Туул хурдны зам"-ын ажил (Улаанбаатар хот)	2025	2028	2,384,013.8	780,677.1
15	Чингэлтэй дүүргийн Нутгийн захиргааны байрны барилга (Улаанбаатар хот)	2024	2027	64,800.0	20,000.0
16	Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн дулааны цахилгаан станц, бохир ус цэвэрлэх байгууламжийн ажил (Улаанбаатар хот)	2025	2028	224,666.9	50,000.0

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл

Хавсралт 4. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025-2026 он дамжин санхүүжих 2026 онд дамжуулах дүн өндөртэй төсөл, арга хэмжээний жагсаалт (сая төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх он	Дуусах он	Төсөвт өртөг	2025 онд санхүүжихээр батлагдсан дүн	2026 онд дамжуулах дүн
1	Улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний газар чөлөөлөлт, нөхөн олговор (Улаанбаатар хот)	2025	2026	298,235.6	298,235.6	75,821.3
2	Нийтийн эзэмшлийн явган хүний замыг шинээр болон шинэчлэн засварлах ажил (Улаанбаатар хот)	2024	2026	65,352.6	64,430.3	40,508.0
3	Эмээлт аж үйлдвэрийн паркийн дулааны цахилгаан станц, бохир ус цэвэрлэх байгууламжийн ажил (Улаанбаатар хот)	2025	2028	225,500.0	30,000.0	30,000.0
4	Туулын авто замыг Нисэхийн хурдны авто замтай холбож, Наадамчдын авто зам дээгүүр гүүрэн байгууламжийн барилга угсралтын ажил	2025	2026	119,969.8	27,610.6	27,610.6
5	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадын зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот)	2025	2026	39,457.2	39,457.2	26,310.5
6	Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро”-г барих төслийн бүтээн байгуулалтын ажил (Улаанбаатар хот)	2024	2030	8,387,792.7	26,307.4	26,307.4
7	Тоньюукукийн замаас Плейтайм аялал жуулчлалын цогцолбор газар хүртлэх авто зам, замын байгууламж (Налайх дүүрэг, 3 дугаар хороо)	2025	2026	18,600.0	18,600.0	17,176.7
8	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжих төслүүдийн нийслэлийн хариуцах хөрөнгө (Улаанбаатар хот)	2025	2026	20,000.0	20,000.0	20,000.0
9	Хотын аж ахуйн ажил үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж (Улаанбаатар)	2025	2026	45,167.9	45,167.9	15,211.3
10	Хүннү хотын эхний ээлжийн цэвэрлэх байгууламжийн ажил	2025	2027	29,663.7	10,000.0	10,000.0
11	Эрүүл мэндийн байгууллагын агаар сэлгэлтийн системийг сайжруулах ажил (Улаанбаатар хот)	2025	2026	10,000.0	10,000.0	10,000.0

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл

Дугаарыг эрхэлсэн:
Д.Оюунбадам, Нээлттэй Нийгэм Форумын
Засаглалын хөтөлбөрийн менежер

Нээлттэй Нийгэм Форум
Хаяг: Монгол Улс,
Улаанбаатар хот-14240,
Сүхбаатар дүүрэг,
Жамьян гүний гудамж-5/1

Утас: 976-76113207
Веб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn